



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 99125777
цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--|----|
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 3 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 9 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 9 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 10 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 11 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт | 11 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл | 11 |
| 3.5.3 Нэмэлт төсөв | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл | 12 |
| 4.2 Материаллаг байдал | 12 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 12 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 14 |
| 5.1 Залруулсан алдаа..... | 14 |
| 5.2 Зөвлөмж | 14 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЦУОШГ | Цаг уур орчны шинжилгээний газар |
| УЦУОШГ | Ус цаг уур орчны шинжилгээний газар |



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА А.ЭНХЗАЯА ТАНАА

2023.02.16 № 248
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тус байгууллага нь 2022 онд Цаг уур орчны шинжилгээний төвөөс 154.6 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 1.2 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 19.4 сая төгрөгийн түлш шатах тослох материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бараа материалд бүртгэсэн. Цаг уур орчны шинжилгээний төвөөс Дунд ус өртөөний барилгын засварын ажлын санхүүжилтийг шийдэж өгснөөр Цамбагаравын хүчтэн ХХК-тай 15.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж засварыг хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан байна. Хөшөөт хөгжил сангийн санхүүжилтээр Мест сумын цаг уурын өртөөний тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг 16.7 сая төгрөгөөр Гэгээнтэн овоо ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан 1

021020212

зорилтын хүрээнд 23 арга хэмжээ, Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ 1 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 95.4 хувьтай гүйцэтгэн ажиллажээ. 2021 онд аймагт шилдэг байгууллагаар шалгаран 0.3 сая төгрөгөөр шагнуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х. БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-------------------------------|-------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>87,338,332.4</u> | <u>231,788,771.0</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 87,338,332.4 | 231,788,771.0 |
| 351 | Түүхий эд материал | 76,819,156.4 | 223,223,271.0 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 76,819,156.4 | 223,223,271.0 |
| 354 | Хангамжийн материал | 10,519,176.0 | 8,565,500.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 961,852.0 | 122,000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,453,949.0 | 1,453,500.0 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,320,000.0 | 3,490,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 3,500,000.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,783,375.0 | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>923,104,997.0</u> | <u>968,114,199.0</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 923,104,997.0 | 968,114,199.0 |
| 392 | Биет хөрөнгө | 715,791,736.8 | 710,575,399.0 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 566,770,864.0 | 581,770,864.0 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (68,879,982.9) | (93,535,751.7) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 458,229,391.8 | 460,879,391.8 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (400,981,375.6) | (411,828,471.2) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 618,179,694.8 | 642,242,754.8 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (464,523,250.2) | (484,741,226.4) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,742,114.0 | 24,342,114.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,895,369.1) | (8,703,926.3) |
| 39217 | Ном | 149,650.0 | 149,650.0 |
| 393 | Биет бус хөрөнгө | 207,313,260.3 | 257,538,800.0 |
| 39301 | Програм хангамж | 550,000.0 | 550,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (275,000.0) | (330,000.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 258,452,948.5 | 258,452,948.5 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (51,414,688.2) | (1,134,148.6) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,010,443,329.4</u> | <u>1,199,902,970.0</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,010,443,329.4</u> | <u>1,199,902,970.0</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,010,443,329.4 | 1,199,902,970.0 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,221,235,417.5 | 1,221,235,417.5 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,221,235,417.5 | 1,221,235,417.5 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (467,630,705.3) | (278,171,064.8) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (467,630,705.3) | (417,350,165.7) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 139,179,100.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 256,838,617.3 | 256,838,617.3 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,010,443,329.4</u> | <u>1,199,902,970.0</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,616,067,689.5 | 1,656,501,201.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 189,082,257.5 | 222,351,691.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 189,082,257.5 | 222,351,691.2 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 189,082,257.5 | 222,351,691.2 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 300,000.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 189,082,257.5 | 222,051,691.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,426,985,432.0 | 1,434,149,510.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,374,772,700.0 | 1,393,803,000.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,374,772,700.0 | 1,393,803,000.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 52,212,732.0 | 40,346,510.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 3,310,000.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.0 | 16,105,440.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,556,532.0 | 20,740,070.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,656,200.0 | 191,000.0 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,504,027,192.5 | 1,517,322,100.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,504,027,192.5 | 1,517,322,100.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,427,829,092.5 | 1,482,807,800.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,096,100,200.0 | 1,164,639,745.9 |
| 210101 | Үндсэн цалин | 791,588,900.0 | 1,022,407,220.1 |
| 210102 | Нэмэгдэл | 228,066,400.0 | 99,532,025.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,444,900.0 | 42,700,500.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 147,973,500.0 | 146,208,240.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,129,500.0 | 100,852,809.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,961,000.0 | 9,757,396.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,768,800.0 | 9,472,897.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,192,200.0 | 2,883,789.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,922,000.0 | 23,241,347.5 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 34,484,825.0 | 39,323,415.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,942,600.0 | 7,985,900.0 |
| 210302 | Түлш, халаалт | 23,625,025.0 | 25,916,475.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,917,200.0 | 5,421,040.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 58,011,511.5 | 36,847,619.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,237,900.0 | 3,707,385.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,060,701.5 | 11,818,699.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,689,790.0 | 4,886,017.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,023,120.0 | 2,659,059.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 13,776,458.3 |

| | | | |
|-------------|--|-----------------------------|-----------------------------|
| 2105 | Нормативт зардал | 648,000.0 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 648,000.0 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,695,000.0 | 1,858,432.6 |
| 210604 | Урсгал засвар | 3,695,000.0 | 1,149,380.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,813,520.0 | 550,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,813,520.0 | 550,000.0 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,564,573.0 | 7,266,861.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,546,373.0 | 6,508,861.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 198,000.0 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,000.0 | 279,600.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,600.0 | 116,600.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 59,400.0 | 70,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |
| 210807 | Газрын төлбөр | 347,200.0 | 291,800.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 76,537,963.0 | 86,113,486.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,884,078.0 | 29,529,088.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,653,884.9 | 56,584,397.7 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,198,100.0 | 34,514,300.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,456,520.0 | 31,598,168.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 56,456,520.0 | 31,598,168.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 19,741,580.0 | 2,916,132.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,741,580.0 | 2,916,132.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>112,040,497.1</u> | <u>139,179,100.9</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>112,040,497.1</u> | <u>139,179,100.9</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------------|-------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,426,985,432.0</u> | <u>1,434,449,510.0</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>1,426,985,432.0</u> | <u>1,434,149,510.0</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,374,772,700.0 | 1,393,803,000.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,374,772,700.0 | 1,393,803,000.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 52,212,732.0 | 40,346,510.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 3,310,000.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.0 | 16,105,440.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,556,532.0 | 20,740,070.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,656,200.0 | 191,000.0 |

| | | | |
|-------------|--|-------------------------------|-------------------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,399,874,822.0</u> | <u>1,419,449,510.0</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,399,874,822.0 | 1,419,449,510.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,323,676,722.0 | 1,384,935,210.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,096,100,200.0 | 1,166,239,500.0 |
| 210101 | Үндсэн цалин | 791,588,900.0 | 868,728,200.0 |
| 210102 | Нэмэгдэл | 228,066,400.0 | 221,066,400.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,444,900.0 | 76,444,900.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 147,973,500.0 | 145,779,900.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,129,500.0 | 99,130,300.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,961,000.0 | 11,662,400.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,768,800.0 | 9,329,900.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,192,200.0 | 2,332,500.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,922,000.0 | 23,324,800.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,268,200.0 | 37,730,140.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,942,600.0 | 8,085,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | 25,408,400.0 | 24,224,100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,917,200.0 | 5,421,040.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,543,600.0 | 20,905,570.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,084,100.0 | 1,657,000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,574,500.0 | 13,282,370.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,027,400.0 | 4,927,400.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,857,600.0 | 1,038,800.0 |
| 2105 | Нормативт зардал | 424,800.0 | 357,000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 424,800.0 | 357,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,407,900.0 | 1,485,300.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,310,800.0 | 649,900.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 166,200.0 | 133,600.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,930,900.0 | 701,800.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,813,520.0 | 575,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,813,520.0 | 575,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,894,602.0 | 11,652,400.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,876,402.0 | 10,894,400.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 198,000.0 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,000.0 | 279,600.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,600.0 | 116,600.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 59,400.0 | 70,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 347,200.0 | 291,800.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,400.0 | 210,400.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 250,400.0 | 210,400.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,198,100.0 | 34,514,300.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,456,520.0 | 31,598,168.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 56,456,520.0 | 31,598,168.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 19,741,580.0 | 2,916,132.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,741,580.0 | 2,916,132.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>27,110,610.0</u> | <u>15,000,000.0</u> |

| | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 27,110,610.0 | 15,000,000.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 27,110,610.0 | 15,000,000.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 27,110,610.0 | 15,000,000.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 27,110,610.0 | 15,000,000.0 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (27,110,610.0) | (15,000,000.0) |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,221,235,417.5 | 256,838,617.3 | -467,630,705.3 | 1,010,443,329.4 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,221,235,417.5 | 256,838,617.3 | -467,630,705.3 | 1,010,443,329.4 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.0 | 00.0 | 50,280,539.7 | 50,280,539.7 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,221,235,417.5 | 256,838,617.3 | -417,350,165.7 | 1,060,723,869.1 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.0 | 139,179,100.9 | 139,179,100.9 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,221,235,417.5 | 256,838,617.3 | -278,171,064.8 | 1,199,902,970.0 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|--------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1396474100.0 | 1393803000.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1396474100.0 | 1393803000.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1359758700.0 | 1359758700.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1166239500.0 | 1166239500.0 |
| 210101 | Үндсэн цалин | 868728200.0 | 868728200.0 |
| 210102 | Нэмэгдэл | 221066400.0 | 221066400.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76444900.0 | 76444900.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145779900.0 | 145779900.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99130300.0 | 99130300.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11662400.0 | 11662400.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9329900.0 | 9329900.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2332500.0 | 2332500.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23324800.0 | 23324800.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32498500.0 | 32498500.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8085000.0 | 8085000.0 |
| 210302 | Түлш, халаалт | 22074200.0 | 22074200.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2339300.0 | 2339300.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7908400.0 | 7908400.0 |

| | | | |
|-------------|--|---------------------|---------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 628600.0 | 628600.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3813600.0 | 3813600.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2927400.0 | 2927400.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 538800.0 | 538800.0 |
| 2105 | Нормативт зардал | 357000.0 | 357000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 357000.0 | 357000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1405200.0 | 1405200.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 649900.0 | 649900.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 187100.0 | 187100.0 |
| 210604 | Урсгал засвар | 568200.0 | 568200.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 575000.0 | 575000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 575000.0 | 575000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4784800.0 | 4784800.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4026800.0 | 4026800.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 279600.0 | 279600.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116600.0 | 116600.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70000.0 | 70000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 291800.0 | 291800.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 210400.0 | 210400.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 210400.0 | 210400.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36715400.0 | 34044300.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 2446132.0 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.0 | 2446132.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36715400.0 | 31598168.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 34585400.0 | 0.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.0 | 31598168.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2130000.0 | 0.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1396474100.0 | 1393803000.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1396474100.0 | 1393803000.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1396474100.0 | 1393803000.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|---|-------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 40346510.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 40346510.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 40176510.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5311740.0 |
| 210302 | Түлш, халаалт | 2230000.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3081740.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13363770.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1395000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9468770.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2000000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21501000.0 |

| | | |
|-------------|---|------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21501000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 170000.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 170000.0 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 170000.0 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 40346510.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 40346510.0 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3310000.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16105440.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20740070.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 191000.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь "Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ус цаг уур орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах байгаль цаг агаарын болзошгүй аюул орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх цаг аргаар уур амьсгалын таатай орчныг бий болгох нийгмийн хэрэгцээ хангахад оршино." гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- ✓ *Цаг уур орчны шинжилгээний газрын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

ЦУОШГазрын даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны А/62 тоот тушаалаар 2022 оны 05 дугаар сарын 03-наас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлж 2022 оны 05 дугаар 03-ны өдөр 16 цаг 00 минутад Ховд аймаг Ховд сум Аман худаг гэдэг газраас As хэлбэрийн 10 баллын үүлэнд нийт 3 гр урвалж цацаж үйлчилсний үр дүнд Жаргалант, Чандмань, Дунд-Ус, Мянгад сумын нутгаар 0.0 – 1.0 мм хур тунадас орсон байна. Жаргалант, Чандмань, Ховд, Мянгад, Буянт сумын нутаг дэвсгэрт нийт 15933000 м³ талбайд /0.5 мм/ хур тунадас зориудаар нэмэгдүүлж 159.330 сая төгрөгийн 7.9665 сая тонн хурын усыг зориудаар нэмэгдүүлсэн байна.

Говийн их Дархан цаазат газрын "Б" хэсэг болон Алтай өвөр говьд хур тунадас нэмэгдүүлэх ажлыг сүүлийн 4 жилийн хугацаанд амжилттай явуулж байна. 2021 онтой харьцуулахад Алтайн өвөр говиор аэросиноптикийн тохиромжтой нөхцөл бүрдэлт муу, үүлний масс нийт нутгийг хамрахгүй, услаг багатай гол төлөв давхраат бөөн /Sc/ үүл, босоо хөгжлийн тасанг /Cb, Cu/ үүл орж ирж байгаа нь цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй байсан. Алтайн өвөр говьд 9 удаагийн гаралтаар 9ш пуужин харваж хур тунадасны хэмжээг 35-40 хувиар нэмэгдүүлсэн байна.

УЦУОШТ-ийн дарга 96 ажилтан албан хаагчтай 2022 онд хийж гүйцэтгэх төлөвлөгөөг хийлгэж, батлуулан мөрдөн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль, Усны тухай хууль, Хөдөлмөрийн тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр** нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2022 оны А/32 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189.4 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 87,338.3 | 231,788.8 | 144,450.5 |
| Үндсэн хөрөнгө | 923,104.9 | 968,114.1 | 45,008.9 |
| Нийт хөрөнгө | 1,010,443.4 | 1,199,902.9 | 189,459.4 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,221,235.4 | 1,221,235.4 | 0 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,010,443.3 | 1,199,902.9 | 189,459.6 |

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,459.6 мянган төгрөгөөр өссөн материаллаг нөлөө нь бараа материалын данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,396.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,396.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,396.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,393.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь тэтгэвэрт гарахад ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 2.6 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|--------------------|--------------------|----------------|-------------|
| 1 | Ус цаг уур орчны шинжилгээ 71408/80101 | 1,355,913.6 | 1,355,913.6 | 0 | 100 |
| 2 | Холбооны суваг ашигласны төлбөр 71408/80220 | 3,845.1 | 3,845.1 | | 100 |
| 3 | Ажил олгогчоос тэтгэмж 71408/80802 | 36,715.4 | 34,044.3 | 2,671.1 | 92.7 |
| | ДҮН | 1,396,474.1 | 1,393,803.0 | 2,671.1 | 97.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны тайлангаар Засаг даргын захирамжаар цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээнд 11.9, Засаг даргын А/249 захирамжаар тэргүүний байгууллагын шагнал 0.3, дээд шатны байгууллагаас Ховд сумын цаг уурын өртөөний их засварт 15.0, А/753 тоот Засаг даргын захирамжаар мессеж мэдээний 2.0, А/744 тоот Засаг даргын захирамжаар агаарын бохирдолтын тооллогын 1.9, ЦУОШГ-ын А/238 тоот тушаалаар 5.6, байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 3.5 сая бүгд 40.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, шатахууны зардалд 12.9, бичиг хэргийн зардал 2.1, цахилгаан халаалтын зардал 2.2, цэвэр бохир усны зардалд 3.0, шуудан холбооны зардалд 2.0, урсгал засварт 0.5, их засварт 15.0, урсгал үйл ажиллагааны зардалд 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно. Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 02 дугаар сарын 12-ноос 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,517.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Ховд аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 0.5 сая төгрөгийн томилолтын зардлыг 8 албан хаагчид олгосон байна. Энэ нь ажилчид бэлчээрийн төлөв байдлын судалгааны ажлаар, шалган туслах зэрэг ажлаар ажилласан байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 156 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 3 байна.

Нэмэлт дансаар 32.5 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэлд мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөж мэдээлүүлж залруулсан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шатахуун зарцуулалттай холбоотой 1.1 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------|----------|------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 1 | 1.1 | 1 | 1.1 | 100 |
| Нийт дүн | 1 | 1.1 | 1 | 1.1 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 32.5 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

5.1 Залруулсан алдаа

Аудитаар шилэн дансны системд мэдээллийг дутуу байршуулсан 32.5 сая төгрөгийн алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэж заасны дагуу залруулав

Аудитаар нийт 79.5 сая төгрөгийн 2 алдаа зөрчил² илэрснээс, 79.5 сая төгрөгийн 2 алдааг материаллаг хэмжээний алдаанд тооцохгүйгээр зөвлөмж өгсөн.

5.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 19 нэр төрлийн 3.6 сая төгрөгийн бараа материал, элэгдлээрээ өртгөө нөхсөн 248 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж:Байгууллагад мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үндэслэн хөрөнгийн тооллого хийж хөрөнгө бүртгэн авах, ашиглалтгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах, хөрөнгийг картжуулах ажлыг зохион байгуулах, Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй бол актлах асуудлыг шийдвэрлэх.

2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй 13 нэр төрлийн 75.9 сая төгрөгийн хөрөнгүүд бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"; гэсэн заалттай нийцээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллого хийж шинж чанар, өртгийн хувьд хөрөнгөд бүртгэх тоног төхөөрөмж, тусгай зориулалттай багаж хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэх асуудлыг зохион байгуулах. Цаашид үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------------|------------|-----------------|-----------------------------------|-----------------|--------------------------|----------|------------|-----------------|--------------|----------|----------|----------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлого дутуу мэдээлсэн | 1 | 32,571.5 | 1 | 32,571.5 | 0 | 0 | 1 | 32,571.5 | | | | |
| Дүн | 1 | 32,571.5 | 1 | 32,571.5 | 0 | 0 | 1 | 32,571.5 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|-------------|-----------------|---------------|----------|-----------------|----------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| | | | | | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал | 2 | 79,541.9 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 79,541.9 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 2 | 79,541.9 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 79,541.9 | 0 | 0 | 0 | 0 |


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  У.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:


 117143692
 9066454

Ц.АЗЗАЯА